ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
7 ДУГААР САРЫН МЭДЭЭ

*2017.07.20*

**Газрын удирдлагын хэлтэс**

Газрын төлбөр төвлөрүүлэлт:

Газрын төлбөрийн орлогын мэдээг сар бүр гаргаж татварын хэлтэст хүргүүлдэг бөгөөд хагас жилийн байдлаар 53,75 сая төгрөг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 53,2%-ийн биелэлттэй байна.

Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт:

- 1 байршилд интернетээр дуудлага худалдаа зохион байгуулан ажиллаж 13800000 /арван гурван сая найман зуун мянга/ төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажиллалаа.
- 3 байршилд төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж, зарыг www.govisumber.gazar.gov.mn сайт, “Зууны мэдээ” сонинд байршуулан олон нийтэд ил тод мэдээлж байна. Үүнд:

- Хонхор хотхоны урд талд хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалтыг /2 байршилд 2,4 га газарт/ зохион байгуулахаар
- Сүмбэр суманд 300 га газрыг нарны эрчим хүчний зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор
- Шивээговь суманд 1-р багт 14 байрны хойд талд 0,12 га газрыг эмийн сангийн барилга барих зориулалтаар төсөл сонгон шалгаруулалт тус тус зохион байгуулахаар зарласан.





**Геодези, зураг зүй:**

Аймгийн хэмжээний газар доорх инженерийн шугам сүлжээний зургийг гүйцэтгэгч Бориг тэс ХХК-тай хамтарч 2 өдөр ажиллан дутуу зурагдсан болон зурагдаагүй 35 инженерийн шугам сүлжээ, байгууламжуудыг нэмж зурагт оруулан ажилласан.

Аймгийн баяр наадмыг зохион байгуулах ажилд оролцон ажиллаж наадмын талбайн зохион байгуулалтын зураг хийх болон зургийн дагуу газар дээр нь тэмдэгжүүлэх ажлуудыг 7 сарын 5,6-ны өдрүүдэд хэрэгжүүлэн ажиллав.

*Барилга, хот байгуулалтын чиглэлээр:*

Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон байдал:

1. Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар
2. Нийтийн эзэмшлийн 5-р байрны дээвэр засвар
3. Нийтийн эзэмшлийн явган зам талбайн ажил
4. Шивээговь сумын Нийтийн эзэмшлийн 3, 8-р байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох ажил
5. Нийтийн эзэмшлийн автозамын ажил

6. БТСГ-ын барилгын дотор засвар
7. 2-р цэцэрлэгийн цахилгаан хангамж дотор монтаж угсралт

**Барилгын техник хяналтын чиглэлээр:**

1. Аймгийн төвийн авто зам, явган зам автозогсоол, автозамын өргөтгөлийн ажлыг “Борхойн зам” ХХК гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70%
2. Аймгийн төвийн телекамерийн ажлын гүйцэтгэл 70%
3. Нэгдсэн эмнэлгийн засвар ажлын гүйцэтгэл 50%
4. БТСГ-ын барилгын дотор засварын ажлын гүйцэтгэл 75%
5. Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажлын гүйцэтгэл 10%
6. 1-р байрны фасад засварын ажлын гүйцэтгэл 60%
7. Баянтал сум 4-р сургуулийн спорт зал засварын ажлын гүйцэтгэл 80%

Шивээговь ОНХС

1. Шивээговь сумын нийтийн эзэмшлийн 3, 8-р байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох ажлын гүйцэтгэл 60%
2. Шивээговь сумын төвийг телекамержуулах ажил гүйцэтгэл 70%

Сүмбэр сум ОНХС

1. Нийтийн эзэмшлийн 5 дугаар байрны дээвэр засварын ажлын гүйцэтгэл 95%

**Барилгын материалын чиглэлээр:**

1. Хөрөнгө оруулалтын ажиллуудын гол түүхий эд материалаас 7 төрлийн эмульс, будаг, хулдаас, ус тусгаардлах материал, бетон шоо, явган замын хавтан, хөөсөнцөр зэрэг 7 төрлийн материалаас дээж авч 2 сая гаруй төгрөгийн үнэ бүхий дээжийг БХТ-ийн барилгын материалын лабораторид шинжлүүлээд байна.

2. Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаанд тогтмолжуулах ажлын хүрээнд ГХБХБГ-ын дэргэдэх барилгын материалын лабораторийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлээд байна.





